



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/32

Мөрөн сум

**Хөрөнгө худалдах, актлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа худалдах тээврийн хэрэгслийг хавсралтаар баталж, хөрөнгийг дуудлагаар худалдах, актлах ажлыг зохион байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт зөвшөөрсүгэй.

2. Хавсралтаар баталсан хөрөнгийг байгууллагынхаа данс бүртгэлээс хасах, дуудлагын худалдааны орлогыг журмын дагуу аймгийн хөрөнгө борлуулсны орлогын данс болон холбогдох дансанд төвлөрүүлэхийг орон нутгийн өмчийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.


а. Акталж, данснаас хасах хөрөнгөөс ашиглаж болох эд зүйлийг ялган тоолж, үнэ тогтоон эргэлтийн хөрөнгийн бүртгэлд тусган ашиглах, тогтоосон журмын дагуу худалдан борлуулах;

б. Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

в. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах;

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Төмөрхуяг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.МӨНГӨНХУЯГ

Өмч  
А.ЭНХИЙН  
2023.10.20  
Х.С.Х  
2023.10.20

6712001249

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын даргын 2023 оны 10  
дугаар сарын 20-ны өдрийн  
199 дугаар захирамжийн хавсралт

а/ Тээврийн хэрэгсэл

| №          | Аймаг, сумын нэр | Байгууллагын нэр                      | Хөрөнгийн нэр       | Ашиглалтад орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Балансын үнэ /төг/   | Байгуулсан элгдэл /төг/ | Үлдэгдэл үнэ /мян.төг/ | Тайлбар                                                                                                   | Байгууллагын санал /төг/ | ОНӨГ-ын үнийн санал /төг/ | Аймгийн ИТХ-ын шийдвэр /төг/ |
|------------|------------------|---------------------------------------|---------------------|---------------------|-------------|------------|----------------------|-------------------------|------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|---------------------------|------------------------------|
| 1          | Мөрөн сум        | Мөрөн сумын Засаг даргын тамгын газар | Lexus 470, ХӨҮ-0300 | 2018                | ш           | 1          | 44,850,000.00        | 40,489,590.00           | 4,360,410.00           | Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 26 дугаар захирамж | Актлах                   | Худалдах, 4,500,000       | Худалдах, 4,500,000          |
| <b>Дүн</b> |                  |                                       |                     |                     |             |            | <b>44,850,000.00</b> | <b>40,489,590.00</b>    | <b>4,360,410.00</b>    |                                                                                                           |                          |                           |                              |

000